



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2013 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А-138

Улаанбаатар хот

Ганкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журамд өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралтад дараах өөрчлөлтийг оруулж хавсралтаар шинэчлэн баталсугай:

1) Б10.5 дахь хэсэгт “Орон сууцаар барьцаалагдсан зээл” гэснийг “Орон сууцны ипотекийн зээл” гэж;

2) Б10.6 дахь хэсэгт “Орон сууцаар барьцаалагдсан зээл” гэснийг “Дэд хөтөлбөрүүдийн зээл”, “эрсдэлээр жигнэх хувийг 0 хувь” гэж;

3) Б10.7 дахь хэсэгт “Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарыг дэмжих зээл” гэснийг “Барилга, боловсруулах үйлдвэр, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны зээл”, “эрсдэлээр жигнэх хувийг 70 хувь” гэж;

4) Б13-т “Засгийн газрын үнэт цаас болон засгийн газрын баталгаатай үнэт цаас /төгрөгийн, цэврээр/” гэснийг “Засгийн газрын үнэт цаас болон засгийн газрын баталгаатай үнэт цаас /цэврээр/” гэж;

5) Б14-т “Засгийн газрын үнэт цаас болон засгийн газрын баталгаатай үнэт цаас /валютын, цэврээр/” гэснийг “Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)” гэж, “эрсдэлээр жигнэх хувийг 50 хувь” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Дээрх журамд өөрчлөлт орсонтой холбоотойгоор барилга, боловсруулах үйлдвэр, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарын зээлийн тайланг (Сангийн сайдын 2011 оны 103 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт буюу Үндэсний статистикийн хорооноос дагаж мөрддөг ангилалын дагуу) цаашид сар бүр Монголбанкны Хяналт шалгалтын газарт ирүүлж байхыг бүх банкны гүйцэтгэх захирлуудад даалгасугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганбат)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

14-1000

Tushaal 2013.doc